



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
БОЛОВСРОЛ, СОЁЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/14

Чойр


Г Үр дүнгийн урамшуулал олгох тухай Г

Төрийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 31 дүгээр зүйлийн 31.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 46 дугаар зүйлийн 46.4, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журам”, Сангийн сайдын 2012 оны 238 дугаар тушаалаар баталсан “Төсвийн урамшуулал олгох хувь, хэмжээ, шалгуур үзүүлэлт, түүнийг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 4.10.1 дэх заалт, Боловсрол, соёлын газрын даргын 2016 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Говьсүмбэр аймгийн Боловсрол, соёлын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2016 онд төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж, төрийн албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр А, В үнэлгээтэй дүгнэгдсэн, сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн Б.Болормаа, математик, статистик хариуцсан мэргэжилтэн А. Баярцэнгэл, соёл хариуцсан мэргэжилтэн Б. Гарамсан нарт тус бүр 190,000 /нэг зуун ерэн мянга/ төгрөгийн мөнгөн урамшуулал олгосугай.


2. Урамшуулалд шаардагдах 570,000 /таван зуун далан мянга/ төгрөгийг шагнал урамшууллын зардлаас гаргахыг Төсвийн мэргэжилтэн бөгөөд нягтлан бодогч /С.Батцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




С. ЭНХ-АМГАЛАН

Боловсрол, соёлын газрын даргын
2016 оны 07 сарын 26-ны өдрийн А/14
дугаар тушаалын 1-р хавсралт



**Боловсрол, соёлын газрын мэргэжилтнүүдийн 2016 оны үр дүнгийн гэрээний
эхний хагас жилийн үнэлгээ**

№	Мэргэжилтнүүдийн нэр	Нийт ажил үйлчилгээ	Тусгай захиалгат	Мэдлэг чадвараа дээшлүүлэх	Нийт хувь
1	Б.Болормаа	91.9	90.0	89.0	90.3
2	А.Баярцэнгэл	93.1	84.7	90.0	89.3
3	С.Батцэцэг	83.0	95.3	83.4	87.2
4	Б.Гарамсан	91.0	89.0	81.0	87.0

Дүгнэсэн:
БСГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч  С.Энх-Амгалан